

**Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт бүртгүүлэхэд тавигдах шаардлага,
болзол (2024 он)**

(1) Япон хэл, Япон соёл судлаач оюутан

- Монгол Улсын иргэн байх.
- 1994 оны 4 сарын 2-ноос 2006 оны 4 сарын 1-ний хооронд төрсөн байх
- Монголын их, дээд сургуулийн 2 эсвэл 3 дугаар курсын оюутан бөгөөд япон хэл, япон соёлыг үндсэн мэргэжил хэмээн сонгон суралцаж байх. Чөлөө авсан оюутнууд шалгалтад орох эрхгүй болно.
- Японы их, дээд сургуульд япон хэлээр суралцахад хангалттай япон хэлний мэдлэг чадвартай байх.
- Бие болон сэтгэцийн хувьд эрүүл байх.
- Японы их сургуулийн заасан хугацаанд (үндсэндээ 9 ба 10 сар) Японд очих боломжтой байх.
- Японд очих үед заавал "Оюутан" ангиллын виз авснаар хилээр нэвтрэх боломжтой. (Японд очсоныхоо дараа визнийхээ "Оюутан" ангиллыг өөрчилсөн тохиолдолд өөрчилсөн цагаас эхлэн Япон Улсын тэтгэлэгт оюутан хэмээх эрхээ алдана гэдгийг анхаарна уу).
- Цэргийн албан хаагч болон цэргийн багууллагад харьяалагдаггүй байх.
- Урьд нь Япон Улсын Засгийн газрын (БСШУЯ) –ын тэтгэлэг авч байгаагүй байх.
- Хэдийнэ хувийн зардлаар Японы их сургуульд суралцаж байгаа эсвэл тус хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө хувийн зардлаар Японы их сургууль зэрэгт суралцахаар төлөвлөж байгаагүй байх. (Харин одоо Японд хувийн зардлаар суралцаж байгаа боловч тус хөтөлбөр хэрэгжиж эхлэх хугацаанаас өмнө Японы их сургуулий төгсөж Монголд буцаж ирэх нь тодорхой бол энэ шалгалтыг өгөх боломжтой)
- Энэ хөтөлбөрөөр хэрэгжих тэтгэлэгтэй давхцан Япон Улсын Засгийн газар (БСШУЯ)-аас бусад байгууллагаас тэтгэлэг авч байгаа эсвэл хамрагдах өргөдөл өгөөгүй байх.
- Хөтөлбөр дууссаны дараа заавал сурч байсан их сургуульдаа сурч япон хэл, япон соёлыг үргэлжлүүлэн сурах.

(2) ЕБС-ийн багшийн мэргэжил дээшлүүлэх курс

- Монгол Улсын иргэн байх.
- 1989 оны 4 сарын 2-ноос хойш төрсөн байх.
- Их дээд сургууль эсвэл багшийн сургууль төгссөн байх
- Монголын ЕБС-ийн үндсэн багшаар багшилж байгаа бөгөөд 2024 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар үндсэндээ 5 ба түүнээс дээш жил тасралтгүй багшилсан туршлагатай байх. Харин их, дээд сургуулийн багш хамрагдах боломжгүй.
- Япон хэлийг идэвхтэй сурах хүсэлтэй байх, Японы талаарх сонирхолтой бөгөөд Японд очсон хойноо ч өөрийн зүгээс Япон орны тухай ойлголтоо идэвхтэй гүнзгийрүүлэх хүсэлтэй байх. Мөн Японд судалгааны ажилд оролцож, Японд амьдрах чадвартай байх.
- Бие болон сэтгэцийн хувьд эрүүл байх.
- Японы их сургуулийн заасан хугацаанд (үндсэндээ 9 буюу 10 сар) Японд очих боломжтой байх.

- Японд очих үед заавал "Оюутан" ангиллын виз авснаар хилээр нэвтрэх боломжтой. (Японд очсоныхоо дараа визнийхээ "Оюутан" ангиллыг өөрчилсөн тохиолдолд өөрчилсөн цагаас эхлэн Япон Улсын тэтгэлэгт оюутан хэмээх эрхээ алдана гэдгийг анхаарна уу).
- Цэргийн албан хаагч болон цэргийн багууллагад харьяалагдаггүй байх.
- Урьд нь Япон Улсын Засгийн газрын (БСШУЯ) –ын тэтгэлэг авч байгаагүй байх.
- Хэдийнэ хувийн зардлаар Японы их сургуульд суралцаж байгаа эсвэл тус хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө хувийн зардлаар Японы их сургууль зэрэгт суралцахаар төлөвлөж байгаагүй байх. (Харин одоо Японд хувийн зардлаар суралцаж байгаа боловч тус хөтөлбөр хэрэгжиж эхлэх хугацаанаас өмнө Японы их сургуулий төгсөж Монголд буцаж ирэх нь тодорхой бол энэ шалгалтыг өгөх боломжтой)
- Энэ хөтөлбөрөөр хэрэгжих тэтгэлэгтэй давхцан Япон Улсын Засгийн газар (БСШУЯ)-аас бусад байгууллагаас тэтгэлэг авч байгаа эсвэл хамрагдах өргөдөл өгөөгүй байх.
- Хөтөлбөр дууссаны дараа заавал ажиллаж байсан их сургуульдаа багшийн ажилдаа эргэн орж судалгааны үр шимийг ашиглах.